

ЗАВХАН АЙМГИЙН ИТХ-ЫН СОНГУУЛЬД АРДЧИЛСАН НАМААС  
ДЭВШҮҮЛЖ БҮЙ МОНГОЛ ӨРХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

НЭГ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

Төрийн үйлчилгээг түгжрэлгүй хүргэнэ.

1. Төрийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах нээлттэй тогтолцоог бүрдүүлж нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа хамтын өргөжүүлэх бүтээлч арга хэмжээ зохион байгуулна.

2. Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдийн саналд тулгуурлан шийдвэр гаргах зорилгоор “Ард иргэдээ сонсох аян”, төрийн үйлчилгээг ард иргэдэд ойртуулах зорилгоор Төрийн цогц үйлчилгээг багт зэрэг арга хэмжээг өргөжүүлэн хэрэгжүүлнэ.

3. Төрийн албан хаагчдын сонгон шалгаруулалт, ажлын ур чадвар, үнэлгээ, гүйцэтгэл, мөн төрөөс үзүүлж буй бүх төрлийн хөнгөлөлт, зээл, тусламжинд хамрагдагсын тухай, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаар ил тод шуурхай мэдээллэдэг “Цахим төрийн алба” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

4. Авлигын эсрэг-Авлигаас ангид аймаг дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

5. Төрийн албан хаагчийн сурч боловсрох, нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн мэргэшсэн тогтвортой байх тогтолцоог бүрдүүлнэ.

ХОЁР. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Хүний төлөө төрийн бодлого хэрэгжүүлнэ.

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон болон олон хүүхэдтэй эрхэлсэн тодорхой ажилгүй идэр насны эрэгтэйчүүдэд зориулсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” тусгайлсан хөтөлбөрийг сум бүрт хэрэгжүүлж, ажлын байр, хувийн өмчтэй болоход нь дэмжлэг үзүүлнэ.

2. Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй болон нийгмийн эмзэг бүлэг, өрх толгойлсон иргэдийг нийгмийн хамгааллын хуулийн дагуух тэтгэмж, тусламж дэмжлэгт жигд хамруулж, тэдгээрт зориулсан “Нийгмийн хамгааллын төв” байгуулна.

3. Хүүхэд, ахмад настанууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ сонсдог өдөртэй болно.

4. Нийтийн биеийн тамирын талбай, хүүхдийн тоглоомын талбайг 24 суманд бүрэн хэрэгжүүлнэ.

5. Хүүхэд, Залуучуудын соёл амралтын хүрээлэн байгуулж, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломжийг бүрдүүлнэ.

ГУРАВ. ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЖ,  
АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Ажлын байр амьдралын баталгаа

1. Сумын хөгжлийн сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлж 200 аас доошгүй сая төгрөгт, Аймгийн жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн эх үүсвэрийг 5 тэрбумаас доошгүй төгрөгт хүргэж жижиг дунд үйлдвэрийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх эх үүсвэрийг хүртээмжтэй болгоно.



2. Сум бүрт “Нэг сум нэг үйлдвэрлэл” хөтөлбөр хэрэгжүүлж сумдад ажлын байр нэмэгдүүлнэ.

3. Улиастай хотод автомашин, сэлбэгийн худалдаа, засвар үйлчилгээний Автопарк байгуулж, тээврийн хэрэгслүүдийн ашиглалт, засвар үйлчилгээг сайжруулан, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

4. Сум бүрт халуун ус, үсчин гоо сайхан, фото зурагчин, нотариат, компьютер ба гар утас, цахилгаан хэрэгслийн засвар үйлчилгээ, нарийн боовны цех, оёдол хувцас захиалга, гутал засвар, дугуй болон машин засвар, гагнуур зэрэг нийтийн ахуйн үйлчилгээний төвийг 24 сумандaa ээлж дараатай бий болгоно.

5. Хэрэглэгч аймгаас үйлдвэрлэгч аймагт шилжих зорилтыг эрчимжүүлж, үзэсгэлэн худалдаа хамтын ажиллагааг өргөжүүлж өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлнэ.

## ДӨРӨВ. ХӨДӨӨ АЖ АХУЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР

### Хөдөө аж ахуй хөгжлийн гарц

1. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн парк байгуулах боломжийг судалж олон улсын стандартын шаардлага хангасан экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжиж экспортонд гаргах бодлого баримтална.

2. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжиж Фермерийн аж ахуй байгуулах, хуурай сүү боловсруулах, цөцгийн тос үйлдвэрлэх, мах, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.

3. ХАА-н техник хэрэгслийг хөнгөлөлттэй үнээр нийлүүлэх ба Улиастай, Тэлмэн, Тэс сумдад ХАА-н машин механизмын засвар үйлчилгээний Автопаркуудыг байгуулж, газар тариалангийн үйлдвэрлэлийг найдвартай машин механизмаар хангана.

4. Мал сүргээ таван хошуу малаар ёсгөн, аймгийн нийт малын тоог ....д хүргэх бодлого баримтална. Мөн малын үүлдэр угсааг сайжруулах, сүргийн бүтцийг зохистой хэмжээнд барихад малчдад дэмжлэг үзүүлнэ.

5. Малын халдварт өвчинтэй тэмцэж, малын үзлэг, тарилга туулгын чанарыг сайжруулж, мал сүргийг эрүүлжүүлэхэд гадаадын эмч мэргэжилтнүүдтэй хамтран ажиллана.

6. Малчдынхаа амьжиргааг дээшлүүлэх мал аж ахуйн салбарт ажиллагсдын тоог нэмэгдүүлэх “Сайн малчин” хөтөлбөр, залуу малчин өрхийг дэмжсэн “Малжуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.

7. Хүн амын хүнсний аюулгүй байдалд сайжруулж, нутгийн хөрсөнд ургасан чанартай хүнсний ногоогоор хүн амыг жилийн туршид хангах зорилгоор Улиастай суманд 500 тоннын багтаамжтай хүнсний ногооны төвлөрсөн зоорь барина. Мөн хүлэмжийн тариалалтыг дэмжин, нөөшилсөн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

8. Завханы улаан хальс сармисны тариалалт борлуулалтыг дэмжиж Монгол брэнд бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх, гадаадад экспортлоход дэмжлэг үзүүлнэ.

## ТАВ. НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР

### Аялал жуулчлал хөгжсөн ногоон бүс нутаг болно.

1. Улаанбаатар Улиастайг холбосон дэд бүтэцийг сайжруулж, Говь-Алтай, Завхан, Хөвсгөл аймгуудыг холбосон аялал жуулчлалын шинэ маршрут гаргаж жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

8117144190  
ИЮА0110 9039376

2. Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэд, аж ахуйн нэгжид жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх, байгаль орчинд ээлтэй ариун цэврийн байгууламжийг шинээр байгуулах, шинэчлэл хийхэд нь зориулж хөнглөлттэй зээл олгоно.

3. Байгаль орчин, ялангуяа голын ай сав, булаг шанд, ой модыг хайрлан хамгаалах, нөхөн сэргээх, арчилж цэвэрлэх талаархи сургалт сурталчилгааны компанийт ажлыг үе шаттайгаар тогтмол явуулж, ой мод, гол горхи, булаг шандыг хамгаалах аж ахуйн нэгж, иргэдийн нөхөрлөлийн үйл ажиллагааг түүштэй дэмжинэ.

4. Байгаль орчин, эх дэлхийгээ хайрлан хамгаалах чиглэлээр хүүхэд залууст зориулсан эко боловсролын тусгай хөтөлбөр хэрэгжүүлж, тэдгээрийн байгаль хамгаалах санаалтга, сайн дурын хөдөлгөөнийг урамшуулан идэвхижүүлнэ.

5. Сум бүрийн хог боловсруулах менежментийг сайжруулж, дахин боловсруулах хогийг ялгах, боловсруулах үйлдвэр бий болгоно.

6. Өөрийн эзэмшил талбайгаа зүлэгжүүлэх, цэцэрлэгжүүлэх, мод тарих, цэцэг тарих иргэдийн санаачилгыг дэмжин, "Иргэн бүр мод тарья, тарьсан модоо ургуулья" урамшуулалт аян, хөдөлгөөн өрнүүлнэ.

7. Жуулчны бааз, жуулчны гэр хотхоны үйл ажиллагааг дэмжин, оюутан залуусыг хөтчөөр ажиллуулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.

8. Уул уурхайн лиценз нэмж олгохгүй, тоог цөөлж уул уурхайгүй аймаг болно.

9. Доной аялал жуулчлалын мэдээллийн төвийг ашиглалтад оруулж Хар нуур үндэсний парк хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

## ЗУРГАА. СОЁЛ, СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

### Эрүүл чийрэг монгол хүн эх орны баялаг

1. Засгийн газрын урамшуулал бүхий олимпийн төрлүүдээр амжилт гаргаж байгаа тамирчид, тэдгээрийн багш, дасгалжуулагчдыг дэмжих тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2. Оюуны спорт болох шатрын спортыг дэмжих цогц бодлого хэрэгжүүлж, аймгаасаа тив, дэлхийн аварга төрүүлэх зорилготой ажиллана.


3. Үндэсний бөх, морь, сур, шагайн харвааны спортыг тууштай хөгжүүлж, бүх төрлийн дэмжлэг үзүүлнэ.

4. Хангайн нурууны өндөр уулын бүсэд гадаадын болон өөрийн орны тамирчдын бэлтгэл сургуулилт хийх өвлийн спортын бааз байгуулах зорилгоор гадаадын хөрөнгө оруулалт татах санаачилга гарган ажиллана.

5. Улиастай хотод баригдаж буй 800 хүний суудалтай Хөгжит Жүжгийн театрыг ашиглалтанд оруулна.

6. Хүүхэд залуучуудын спорт урлагийн наадмыг олон төрөөр тогтмол зохион байгуулж, тэдний авьяас чадварыг хөгжүүлнэ.

7. Сонирхогчдын болон мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг дэмжих, контент гарааны бизнесийг дэмжих замаар монгол үндэстний өв соёлыг дэлгэрүүлж сурталчилна.



## ДОЛОО. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР

Эрүүл мэнд эрхэм баялаг

1. Иргэн бүрийг эрүүл мэндийн эрсдлээс хамгаалах цахим карттай болгоно.
2. Иргэдийг эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн сантай болгож, даатгалтай иргэн харьяалал харгалзахгүй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломж олгоно.
3. Сумын эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарт суурилсан санхүүжилтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, боловсронгуй болгоно.
4. Эх хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, амьдралын түвшин доогуур өрхийг эрүүл мэндийн эрхийн бичгээр ханган, үзлэгт хамруулах бодлого баримтална.
5. Нэгдсэн эмнэлгийн дэргэдэх алсын зайн оношлогооны төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, Улсын Клиникийн эмнэлгүүд, Эх нялхас, Гэмтэл согог судлалын төвтэй телемедицины сүлжээгээр холбогдон орон нутагтаа оношлуулж, эмчлүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.
6. Эмнэлгийн яаралтай тусламжийн үйл ажиллагааг хурдан шуурхай, хүртээмжтэй болгож, техник тоног төхөөрөмжөөр ханган, явуулын эмнэлгиний үйл ажиллагааг өргөжүүлнэ.
7. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, өрхийн эмнэлгүүд, сумдын эмнэлгэд ажиллаж байгаа эмч, сувилагч, нарийн мэргэжлийн эмч нарын хүрэлцээг нэмэгдүүлж, тэднийг дотоод гадаадын мэргэших сургалтанд хамруулж, мэдлэг мэргэшлийг тогтмол дээшлүүлэх арга хэмжээ авна.
8. Хувийн эмнлэг, рашаан сувиллын үйл ажиллагааг дэмжиж, уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухааны оолттой хослуулан эмчилгээ, сувилгааны чанар, үр өгөөжийг дээшлүүлнэ.
9. Хүүхэд, гэр бүл, цэцэрлэг сургуулийн орчин эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зөв амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, ажлын байр, орчны эрүүл мэндийг сайжруулах бодлогыг нийгмийн эрүүл мэндийн үндсэн чиглэл болгож, “Эрүүл мэндийг дээдлэгч байгууллага” хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.
10. Сайн эмч хөтөлбөрийн үр дүн сайжруулах, эрүүл мэндийн салбар ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.

## НАЙМ. БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Оюунлаг Завханчуудаа дэмжинэ.

1. Багшлах боловсон хүчний ур чадвар, бүтээмж, ажлын гүйцэтгэл дээр суурилсан цалин, урамшууллын тогтолцоог нэвтрүүлэх замаар багшийн ажлыг шударгаар үнэлж, мэргэжлийн нэр хүнд, үнэлэмжийг өсгөн, цалингаараа хангалуун амьдрах, орон сууц худалдан авах боломжийг бүрдүүлсэн “Сайн Багш”, “Сайн Оюутан” хөтөлбөрийг өргөжүүлэн хэрэгжүүлж, багшлах боловсон хүчнийг чадваржуулах арга хэмжээг авч ажиллана.
2. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагааг хөдөлмерийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулж, элсэгчдийг ажил олгогчийн гэрээ, захиалга дээр тулгуурлан элсүүлж, төгсөгчдийг ажлын байраар хангах нөхцлийг бүрдүүлнэ.
3. Сургуулийн өмнөх боловсролд зориулсан хүүхэд харах үйлчилгээг нэвтрүүлж, өдөр өнжүүлэх бүлэг байгуулах, шаардлагатай багт гэр цэцэрлэгийг байгуулах ажлыг эрчимжүүлж сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлнэ.

8117144190  
ИЮА0110 9039376

4. Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг зориулалтын сурах бичиг, тоног төхөөрөмжөөр хангаж, коллеж, их дээд сургуульд элсэн суралцах боломжийг нэмэгдүүлж, өндөр хөгжилтэй оронд оюутан сургах тогтолцоог шинэчлэн сургуулиудын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

5. Хүүхэд залуусын хөгжлийг дэмжих “Гурван тулгуурт бодлого”-ыг өргөжүүлэн түүх соёл, зан заншил, өв уламжлалаа дээдэлсэн, төрөлх нутгаа хайлласан ирээдүйн хөгжлийн эзэн багачууд бэлтгэх төрөл бүрийн хөтөлбөр хэрэгжүүлнэ.

6. Сургууль, цэцэрлэгүүд өөрийн хэрэгцээг хангах туслах аж ахуйг эрхлэх боломжийг дэмжинэ.

#### ЕС. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Нутагтаа сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

1. Улиастай хотод Дулааны Цахилгаан Станц барьж ашиглалтанд оруулна. Алтай Улиастай чиглэлийн хэт урт, алдагдал ихтэй цахилгаан дамжуулах шугамаар нийлүүлэгдэж байгаа эрчим хүчиний үр ашгийг сайжруулах зорилгоор 30 МВТ аас доошгүй хүчин чадал бүхий эрчим хүчиний эх үүсвэр барина.

2. Иргэд залуу гэр бүл, төрийн албан хаагчдийг орон сууцжуулах хөтөлбөрт үе шаттайгаар хамруулах бодлого хэрэгжүүлнэ.

3. Сумдыг инженерийн нэгдсэн шугам сүлжээнд үе шаттайгаар холбох замаар сумандаа сайхан амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

4. Улиастай хотыг дулааны нэгдсэн сүлжээнд холбож, 24 сумдад нэгдсэн халаалтыг ээлж дараатай ашиглалтанд оруулж, аж ахуй нэгж байгууллагууд, гэр хорооллыг цэвэр бохир усны инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг хэрэгжүүлнэ.

5. Улиастай сумын Богдын гол дээр Төмөр бетон гүүрийг шинээр барьж ашиглалтанд оруулна.

6. Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн хатуу хучилттай замыг бүрэн холбож, Улиастай-Алтай чиглэлийн замыг хатуу хучилттай болгоно.

7. Хөгжлийн Завхан сан нутгийн бүтээн байгуулалтын хөтөлбөр хэрэгжүүлнэ.

8. Шаардлагатай сумдын Сургууль, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төв, ЗДТГ-ын байр зэргийн засвар үйлчилгээ хийж, шинэчлэх арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлнэ.

9. Гадаадын төсөл хөтөлбөртэй хамтран ажиллах боломжийг судалж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

ИЮАнти 9039376